



Сумын ИТХ-ын ээлжит бус 4 дүгээр хуралдааны

06 -р тогтоолын 11 -р хавсралт

СУМЫН ТӨВ, ГУДАМЖНЫ НЭРШИЛ

| Д/д | Багийн нэр    | Гудамжны нэр /хуучин/ | Гудамжны нэршил /шинэ/ |
|-----|---------------|-----------------------|------------------------|
| 1   | Талын нар баг | Баян                  | Баян                   |
| 2   | Талын нар баг | Зоог                  | Зоог                   |
| 3   | Талын нар баг | Малчин                | Малчин                 |
| 4   | Цог баг       | Орон сууц             | Орон сууц              |
| 5   | Цог баг       | Тойром                | Тойром                 |
| 6   | Цог баг       | Сургууль              | Сургууль               |
| 7   | Цог баг       | Цагаан хад            | Цагаан хад             |
| 8   | Цог баг       | Бөхт                  | Бөхт                   |
| 9   | Цог баг       | Ажнай                 | Ажнай                  |
| 10  | Цог баг       | Хийморь               | Хийморь                |
| 11  | Цог баг       | Сумын төв             | Төв                    |

СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Сумын ИТХ-ын ээлжит бус 4 дүгээр хуралдааны

06 -р тогтоолын 2 -р хавсралт

БАГИЙН ТӨВ, ТҮҮХ СОЁЛ, БАЙГАЛИЙН ДУРСГАЛТ ГАЗАР, РАШААН  
СУВИЛАЛЫН БАЙРШИЛ

| № | Нэр                             | Байршил                        | Координат    |               |
|---|---------------------------------|--------------------------------|--------------|---------------|
|   |                                 |                                | X            | Y             |
| 1 | Шар ханангийн агуй              | Сумын төвөөс зүүн хойш 45 км   | 45° 33' 071" | 108° 19' 794" |
| 2 | Аврахын хийдийн туурь           | Сумын төвөөс баруун тийш 30 км | 45° 13' 40"  | 108° 1' 30"   |
| 3 | Их баянгийн уулын Харангадын ам | Сумын төвөөс баруун хойш 23 км | 45° 19' 10"  | 108° 2' 0"    |
| 4 | Шилийн зоо тахилгат уул         | Сумын төвөөс урагш 34 км       | 44° 58' 0"   | 108° 17' 40"  |
| 5 | Эсгэлэнгийн рашаан              | Сумын төвөөс зүүн хойно 20 км  | 45° 13' 25"  | 107° 54' 10"  |

СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Сумын ИТХ-ын 2016 оны 04 сарын 20-ын өдрийн  
ээлжит бус 4 дүгээр хуралдааны  
06 -р тогтоолын 1 -р хавсралт

## УЛС, ОРОН НУТГИЙН ЧАНАРТАЙ АВТО ЗАМУУДЫН ЧИГЛЭЛ

### 1. Улсын чанартай авто замын чиглэл:

- Сумын төв-Хөтөл-Өлзийт-Арговь-Говьсүмбэр аймаг
- Сумын төв-Талын нар-Хүрэнцав-Ноодой-Дорноговь аймаг
- Сумын төв-Ихбаянгийн уул-Хамарцагаан жаргалан уул-Дундговь аймаг

### 2. Орон нутгийн чанартай автозамын чиглэл:

- Сумын төв-Хавирга-Дэн-Шилийн зоо уул-Дорнговь аймгийн Мандах сум
- Сумын төв-Магнай-Зоог-Дорноговь аймгийн Айраг сум
- Сумын төв-Улаан хуц-Зүүнтоодог-Цэгийн хороо- Дундговь аймгийн Өлзийт сум
- Сумын төв-Билүүт-Булаг-Энгэрийн улаан-Дундговь аймгийн Баянжаргалан сум,
- Сумын төв-Багабаян-Босгон-Ажирхай-Дорноговь аймгийн Даланжаргалан сум,
- Сумын төв-Тасын уул-Оорцог толгой-Дорноговь аймгийн Сайхандулаан сум

### 3. Түүх соёл, Байгалийн дурсгалт газар:

- Шар ханангийн агуй /Сумын төв-Билүүт-Хөтөл-Шар ханангийн агуй/
- Аврахын хийдийн туурь / Сумын төв-Үүд-Үзүүр хар Аврахын хийдийн туурь/
- Ихбаянгийн уулын Харангадын ам /Сумын төв-Ихбаянгийн уул/
- Шилийн зооны тахилгат уул /Сумын төв-Хавирга-Дэн-Шилийн зоо/

### 4. Рашаан сувилал

-Эсгэлэнгийн рашаан - Сумын төв-Багабаян-Даравгай-Эсгэлэнгийн рашаан

Сумын ИТХ-ын ээлжит бус 4 дүгээр  
хуралдаан 05-р тогтоолын хавсралт

**СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНГААС ОЛГОСОН ЗЭЭЛИЙН ХҮҮГИЙН ОРЛОГЫН 50  
ХУВИЙГ ЗАРЦУУЛАХ ЗАРДЛЫН ТООЦОО**

| № | Зарцуулах ажил, арга хэмжээ   | Төсөв                    | Тайлбар  |
|---|---|--------------------------|--|
| 1 | Зээлдэгчдэд зориулсан сургалт,<br>зөвлөгөө өгөх арга хэмжээ               | 424170<br>төгрөг         | 2015 оны зээлийн хүүгийн<br>30 хувиас зарцуулна  |
| 2 | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх<br>ажиллагаа                                    | 200000<br>төгрөг         | 2015 оны зээлийн хүүгийн<br>20 хувь болох 282780<br>төгрөгөөс зарцуулна  |
| 3 | Төслийн үйл ажиллагаанд хяналт<br>тавих үед зарцуулах шатахууны<br>зардал | 31000<br>төгрөг          | 2015 оны зээлийн хүүгийн<br>20 хувь болох 282780<br>төгрөгөөс зарцуулна.<br>/Жилд 4 удаа/  |
| 4 | Бичиг хэрэг, зурагт боршур,<br>тайлагнах үйл ажиллагаа                    | 51780                    | 2015 оны зээлийн хүүгийн<br>20 хувь болох 282780<br>төгрөгөөс зарцуулна.<br>/Зээлдэгчдийн хийсэн<br>бараа, бүтээгдэхүүнийг<br>сурталчилах/ |
|   | <b>ДҮН</b>  | <b>706950<br/>төгрөг</b> |  |

**СУМ ХӨГЖҮҮЛЭХ САН**



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ӨНДӨРШИЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2016 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 06

Бөхт

Хаягжуулалтын ажлын тухай

Монгол Улсын Хаягжуулалтын тухай хууль, Засгийн газрын 2013 оны 280 дугаар тогтоолоор батлагдсан “Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах жуам”-ын 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн ээлжит бус IY хуралдаанаас ТОГТООХ нь:

- Сумын нутаг дэвсгэр дэх улс, орон нутгийн чанартай авто замуудын чиглэлийг хавсралт 1-ээр, Түүх соёл, байгалийн дурсгалт газар, амралт сувилалын газрын хаягжуулалтыг хавсралт 2-оор, сумын төвийн хорооллын хаягжуулалтыг хавсралт 3-аар тус тус баталсугай.
- Хаягжуулалтын ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг “Геокад” ХХК-тай хамтарч ажиллахыг үүрэг болгосугай.





ДУНДГОВЬ АЙМАГ  
ӨНДӨРШИЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2016 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 05

Бөхт

Г Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн хүүгийн  
50 хувийг зарцуулах саналыг батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 153 дугаар тогтоолоор батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бурдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.8, 3 дугаар зүйлийн 3.5.7 дахь заалтуудыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн ээлжит бус IY хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Сум хөгжүүлэх сангаас олгох зээлийн хүүгийн тухайн жилийн орлогын 30 хувь 424170 төгрөгийг зээлдэгчдэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалтад, 20 хувь болох 282780 төгрөгийг сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төслийн үйл явц, үр дунд хяналт тавих үйл ажиллагаанд зориулан хавсралтад дурдсаны дагуу зарцуулахыг зөвшөөрсүгэй.

2. Зээлийн хүүгийн орлогын 50 хувийн зарцуулалтын талаар сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд тайлагнахыг сумын Засаг дарга Н.Мөнхцэцэгт даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид болон Нарийн бичгийн дарга наарт үүрэг болгосугай.

ДАРГА  О.ЦОЛМОН



ДУНДГОВЬ АЙМАГ  
Өндөршил сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын  
тогтоол

2016 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 04

Бөхт

Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх  
төслийн сонгон шалгаруулалтын тов зарлах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 153 дугаар тогтоолоор батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 1 дүгээр дугаар зүйлийн 1.11 дэх заалтыг үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн ээлжит бус IY хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн сонгон шалгаруулалтыг 2016 оны 05 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулахаар тогтоосугай.

2. Сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төслийн санал хүлээх авах, сонгон шалгаруулахдаа Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 4 дүгээр зүйлийг мөрдлөг болгон ажиллахыг Төсөл сонгон шалгаруулах орон тооны бус зөвлөлд үүрэг болгосугай.

3. Зээл олголт, ашиглалт, эргэн төлөлт, сангийн хөрөнгийн зарцуулалтанд хяналт тавьж ажиллахыг Хяналтын зөвлөлд даалгасугай.

ДАРГА



О.ЦОЛМОН



ДУНДГОВЬ АЙМАГ  
ӨНДӨРШИЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2016 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 02

Бөхт

Г Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт,  
зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих чиг  
үүрэг бүхий орон тооны бус зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 153 дугаар тогтоолоор батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 3.3.2 дахь заалтыг үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн ээлжит бус IY хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Хяналтын зөвлөлийн дарга О.Цолмон -Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгч

|        |                |                              |
|--------|----------------|------------------------------|
| Гишүүд | Т.Отгондулам   | -Төрийн сангийн мэргэжилтэн  |
| гишүүн | Д.Ундрахжаргал | -Баялаг бүтээгчдийн холбооны |
|        | Б.Амарсанаа    | - 1 дүгээр багийн иргэн      |
|        | С.Түмэнбаатар  | - 2 дугаар багийн иргэн      |

2. Зээл авсан иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр дүнгийн тайлан, санхүүгийн буюу мөнгөн гүйлгээ, зээлийн эргэн төлөлтийн тайланг гаргуулан авах, Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд улирал бүр хяналт шалгалт хийж, дүнг сумын нийт иргэдэд мэдээлж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хуралдаанаар хэлэлцүүлж байхыг **ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ**-д үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 05 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

О.ЦОЛМОН



ДУНДГОВЬ АЙМАГ  
ӨНДӨРШИЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2016 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 03

Бөхт

Г Сум хөгжүүлэх сангаас 2016 онд нэг төсөлд  
олгох зээлийн дээд хэмжээг тогтоох тухай

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 153 дугаар тогтоолоор батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 3.3.1 дэх заалтыг үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн ээлжит бус IY хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Сум хөгжүүлэх сангаас 2016 онд иргэн, иргэний бүлэгт олгох зээлийн дээд хэмжээг 10000000 хүртэл төгрөгөөр, аж ахуйн нэгжид олгох зээлийн дээд хэмжээг 30000000 хүртэл төгрөгөөр тус тус тогтоосугай.
2. Зээлийн эргэн төлөлт, ажлын байр шинээр бий болгох, төсөл хэрэгжих баталгаа үндэслэл, тооцоо зэргийг харгалзан төслүүдийг сонгон шалгаруулж зээлийн олгох явц үр дүнг хагас, бүтэн жилээр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнаж байхыг Төсөл сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл /Н.Мөнхцэцэг/-д даалгасугай.
3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдэд үүрэг болгосугай.

ДАРГА

О.ЦОЛМОН





ДУНДГОВЬ АЙМАГ  
ӨНДӨРШИЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2016 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 01

Бэхт

Г Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх  
төслийг сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий орон  
тооны бус зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 153 дугаар тогтоолоор батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бурдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 3.3.3 дахь заалтыг үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн ээлжит бус IY хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийг сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Зөвлөлийн дарга Н.Мөнхцэцэг  
Гишүүд Б.Батсүрэн  
хариуцсан мэргэжилтэн

-Сумын Засаг дарга  
- Жижиг дунд үйлдвэрлэлийн асуудал

Баялаг бүтээгчдийн холбооны дарга  
Ч.Мөнхбаяр -1 дүгээр багийн иргэн  
Г.Хонгорзул -2 дугаар багийн иргэн  
О.Уянга - ХААН банкны эрхлэгч  
Ү.Цэрэнпил - Төрийн банкны эрхлэгч

2. Төсөл сонгон шалгаруулах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах ажлыг зохион байгуулж, ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлж ажиллахыг Зөвлөлийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 04 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

О.ЦОЛМОН